

ОРХОН АЙМГИЙН ХӨГЖЛИЙН 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН
/БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗАР /

2025.12.26-ний өдөр

Баян-Өндөр сум

№	Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн	Хөтөлбөрийн үр дүн	Үндсэн үйл ажиллагаа	Төсөл арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин		Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Хэрэгжилтийн хувь	Хэрэгжилтийн тайлбар
							Он	Түвшин				
1	3.5.Идэвхтэй хөдөлгөөн хийдэг иргэдийг нэмэгдүүлнэ.	3.5.1. Нийтийн тамирын ач холбогдлын талаар зөв мэдлэгтэй иргэдийг нэмэгдүүлж орчин нөхцлийг сайжруулна.	Арга хэмжээ	3.5.1.1. Сорилын төв болгон ашиглах спортын А заалны өргөтгөл, засварын ажлыг хийх.	Сорилын төвийн өргөтгөл, засвар ажлын хувь	хувь	2024	Сорилын төвд ашиглагдах тоног төхөөрөмж суурилуулах өрөө танхим байхгүй	сорилын төв байгуулах зааланд өргөтгөл, засвар хийгдсэн байна.	-	-	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 03/13 дугаар тогтоолоор батлагдсан Аймгийн 2025 оны төсвөөс спортын А заалны өргөтгөл, засварын ажлын төсөв хасагдсан.
2			Арга хэмжээ	3.5.1.2. Хийн болон эрүүл мэндийн дасгал хөдөлгөөнийг сурталчилж “Хичээллэе-Өрнүүлэе-Хэвшье” аяныг иргэд, ААНБ-уудын дунд өрнүүлнэ		тоо	2024	24,400 иргэнийг дасгалд хамруулсан	25,000 иргэнийг дасгал хөдөлгөөнд хамруулна	давхардсан тоогоор 41,734 иргэнийг дасгал хөдөлгөөнд хамруулсан.	100%	Тайлант онд “Хичээллэе-Өрнүүлэе-Хэвшье” аяны хүрээнд бүх насны иргэдийн дунд дасгал хөдөлгөөн, алхалт, гүйлтийн биеийн тамирын арга хэмжээг 61 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор 41,734 иргэнийг хамруулсан.Арга хэмжээнд улсын төсвийн 12,2 сая төгрөг, орон нутгийн төсвийн 23,4 сая төгрөгийн хөрөнгийг тус тус зарцуулсан Үүнд: -Төрийн албан хаагчдын дунд “Ажлын байрны цахим дасгалын уралдаан”-д 42 байгууллагын давхардсан тоогоор 16,800 албан хаагч; -Ерөнхий боловсролын сургуулиудын бага ангийн сурагчдын дунд “Нэг анги-Нэг өдөр” завсарлагааны цахим дасгалын уралдаанд 22 сургуулийн 196 бүлгийн

												давхардсан тоогоор 19,200 сурагчид; -“Төгөлдөр Солонго” бүжгийн клубтэй хамтран Шугаман бүжгийн сургалтад давхардсан тоогоор 2200 иргэд; -“Эртэч эрдэнэтчүүд” өглөөний дасгалын арга хэмжээнд 2400 иргэд; -Алхалтын 4 удаагийн арга хэмжээнд 785, гүйлтийн 2 удаагийн арга хэмжээнд 349 иргэдийг тус тус хамруулж ажилласан.
3			Арга хэмжээ	3.5.1.3.Аймгийн хэмжээнд өвлийн спортыг хөгжүүлэн “Эрдэнэт спорт амралтын хүрээлэн” болон бусад газар мөсөн талбай байгуулж хичээллэх нөхцлийг бүрдүүлнэ.	Мөсөн талбайн тоо	Тоо	2024	4	6	Мөсөн талбай 3, цанын зам 3, нийт 6 зам талбай байгуулсан.	100%	Аймгийн хэмжээнд өвлийн спортыг хөгжүүлж цанын зам 3, мөсөн талбай 3, нийт 6 зам талбай байгуулж, тэмцээн уралдаан зохион байгуулах, хүүхэд залуусыг өвлийн спортоор хичээллэх орчин нөхцөлийг бүрдүүлж ажилласан.Үүнд: -Эрдэнэт спорт амралтын хүрээлэнд мөсөн талбай, "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-н Сархиа баазад цанын зам 3, Орос 19-р сургуулийн хоккейн талбай, ерөнхий боловсролын 15 сургуулийн гадна мөсөн талбайг тус тус байгуулж, улсын болон олон хотын аварга шалгаруулах 9 удаагийн тэмцээн уралдаан зохион байгуулж 1350 тамирчид, иргэдийг хамруулсан. -Мөсөн талбай, цана, чаргын зам талбайд 3 иргэн, аж ахуйн нэгж спортын хэрэгслийн түрээсийн үйлчилгээг 4200 гаруй иргэнд үзүүлсэн.

4			Арга хэмжээ	3.5.1.4.Спортын цогцолбор барих зураг төсөв боловсруулах;	Зураг төсөв боловсруулах ажлын хувь	хувь	2024	-	Спорт цогцолборын зураг төсөв батлагдсан байна.	Спорт цогцолборын зураг, төсвийг боловсруулсан.	100%	Аймгийн хэмжээнд спортын барилга байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор шинээр "Эрдэнэт спортын цогцолбор"-ын зураг, төсөв боловсруулах ажлыг орон нутгийн төсвийн 631,0 сая төгрөгийн хөрөнгөөр "Зэд прожект" ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн.
5			Арга хэмжээ	3.5.1.5.Спортын хэрэгслийн /ердийн болон цахилгаан дугуй, цана, тэшүүр, дугуйт цана, дугуйт тэшүүр/ түрээсийн үйлчилгээ үзүүлэх орчин нөхцлийг сайжруулах салбар дундын ажлын хэсэг байгуулах, үнэлгээ хийх;	Түрээсийн үйлчилгээ үзүүлсэн иргэн, аж ахуйн нэгжийн тоо	Тоо	2024	4	4	Унадаг дугуйн замыг хотын төвийн хэсэгт өргөтгөж, орчин нөхцөлийг сайжруулах ажил хийхээр зураг төсөв батлагдсан.	100%	Аймгийн Засаг даргын 2025 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн А/744 дүгээр захирамжаар "Унадаг дугуйн замын нөхцөл байдалд үнэлгээ өгөх, өргөтгөх талаар судлах" салбар дундын ажлын хэсэг байгуулж ажилласан. Ажлын хэсэг 3 удаа хуралдаж, унадаг дугуйгаар явах замын нөхцөлийг сайжруулах зорилгоор хотын төвийн 6 орон сууцны хорооллын авто зам болон явган замын хашлага, шатыг налуулах, боломжит явган замуудыг зааглах шугам тавих ажлуудын зураг, төсвийг "Хот байгуулалт, барилга захиалагчийн алба" УТҮГ боловсруулсан.Унадаг дугуйн замын нөхцөлийг сайжруулах судалгаа тооцоо, зураг, төсвийг аймгийн 2026 оны төсөвт саналаа хүргүүлж, 293,0 сая төгрөгний ажил гүйцэтгэх төсөв батлагдсан.
6			Арга хэмжээ	3.5.1.6.Орон сууцны болон гэр хорооллын дундах амралт, чөлөөт цагийн	Гадаа талбайд зохион байгуулсан	тоо	2024	13	13	Гадаа талбайд 17 удаа арга хэмжээ зохион	100%	Тайлант онд амралт, чөлөөт цагийн талбайд зохион байгуулсан тэмцээн уралдаанд 17 удаагийн арга

				талбайд биеийн тамир спортын уралдаан тэмцээн зохион байгуулж ашиглалтыг сайжруулна.	уралдаан тэмцээн, өдөрлөгий н тоо					байгуулж, 7910 иргэдийг оролцуулсан.		хэмжээнд 7910 иргэдийг хамруулсан.Үүнд: -"Эртэч Эрдэнэтчүүд" өглөөний дасгалын арга хэмжээнд 2400 иргэн; -Хүүхдийн баярын 06 дугаар сарын 01-ний өдрийн арга хэмжээний хүрээнд сагсан бөмбөгийн 3х3 төрөл, даамын тэмцээнд 500 хүүхэд; -Бүх хайраа гэр бүлдээ арга хэмжээний нээлт, залуучуудын аймгийн аварга шалгаруулах спортын 8 төрөлт тэмцээнд 776 гаруй хүүхэд залуучууд; -"Эрдэнэт марафон-2025", Шри Чинмойны нэрэмжит бүх нийтийн гүйлтийн 2 удаагийн арга хэмжээнд нийт 349 хүүхэд, залуучууд; -Монголын хүүхдийн спортын зуны VIII наадмын үдэлт, хаалтын арга хэмжээнд спортын 30 төрлийн 350 өсвөрийн тамирчид; -"Эрүүл Монгол үндэсний хөдөлгөөн"-ий хүрээнд "Бүх нийтийн явган алхалт"-н 4 арга хэмжээнд 785 иргэд; -Эрдэнэт спорт амралтын хүрээлэн, Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэн, Сархиа цанын баазад спортын 10 төрлийн тэмцээн уралдаанд 2750 иргэд, тамирчдыг тус тус оролцуулан зохион байгуулсан
7		3.5.2.Үндэсн ий спортоор хичээллэгчд ийн тоог	Арга хэмжээ	3.5.2.1. Улс, бүсийн чанартай уралдаан тэмцээнийг	Орон нутагт зохион байгуулса н	тоо	2024	6	6	Улс, бүсийн чанартай тэмцээн уралдааныг 15 удаа	100%	Тайлант онд улсын аварга шалгаруулах 9, олон хотын болон бүсийн чанартай 6 тэмцээн нийт улс, бүсийн 15

		нэмэгдүүлнэ		орон нутагт зохион байгуулах;	уралдаан тэмцээний тоо					зохион байгуулж, 4627 тамирчдыг хамруулсан.		удаагийн тэмцээн зохион байгуулж, 4627 тамирчдыг хамруулсан.Улсын аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулахад улсын төсвөөс 20,0 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 23,5 сая төгрөгийг тус тус зарцуулсан.
8			Арга хэмжээ	3.5.2.2.Монголын үндэсний спортын VIII наадамд оролцож амжилтаа бататгана.	Оролцсон тамирчдын тоо	тоо	2022	Монголын үндэсний спортын VII наадамд 103 тамирчид дасгалжуулагч нар үндэсний спортын 12 төрлөөр оролцож багийн дүнгээр Орхон аймаг түрүүлж алтан медаль цомоор шагнагдсан.	Монголын үндэсний спортын VIII наадмын анхан болон шигшээ тэмцээнийг өвөл, зуны 12 төрлөөр зохион байгуулж 103 тамирчин дасгалжуулагч оролцоно.	-	-	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Биеийн тамир, спортын улсын хорооноос Засгийн газрын 2018 оны 183 дугаар тогтоолын дагуу Монголын үндэсний спортын VIII наадмыг 2026 онд зохион байгуулахаар шийдвэрлэсэн.
9			Арга хэмжээ	3.5.2.3. “Иргэдийн спортын наадам”-ыг багийн болон үндэсний спортын 8 төрлөөр зохион байгуулах;	Зохион байгуулсан спортын төрлийн тоо	тоо	2023	Багийн болон үндэсний спортын 8 төрлөөр зохион байгуулж 23 багийн 1163 иргэнийг хамруулсан	Багийн болон үндэсний спортын 8 төрлөөр зохион байгуулна	Спортын 4 төрлөөр зохион байгуулсан.	100%	Аймгийн Засаг даргын 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн А/1028 дугаар захирамжаар “Иргэдийн спортын наадам”-ыг спортын 4 /ширээний теннис олс таталт буудлага, олс таталт, корнхол/ төрлөөр тайлант оны 12 дугаар сарын 06-ны өдөр зохион байгуулж, 22 багийн 460 иргэдийг хамруулсан.Тэмцээний зардалд орон нутгийн төсвийн 12,1 сая төгрөгийн хөрөнгийг зарцуулсан.

10			Арга хэмжээ	3.5.2.4. Үндэсний спортын төрлүүдийг сурталчилж, хичээллэгсдийн тоог нэмэгдүүлэх;	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	тоо	2024	16 удаагийн арга хэмжээнд 8,3 сая төгрөг дэмжлэг үзүүлж, хичээллэгчдийн тоог 60-аар нэмэгдүүлсэн.	18 арга хэмжээ зохион байгуулж, хичээллэгчдийн тоог 30-аар нэмэгдүүлж 1020 тамирчинтай болно.	51 удаагийн тэмцээн уралдаан зохион байгуулж, хичээллэгчдийн тоог 1048-д хүргэсэн.	100%	Тайлант онд үндэсний спортын /үндэсний бөх, шагай, мөсний сур, харваа мөсний шагай/ 5 төрлөөр 51 удаа тэмцээн уралдаан зохион байгуулж, 4428 тамирчдыг хамруулсан. Үүнд: үндэсний бөх 458, үндэсний сур 220, шагай 176, мөсний сур харваа 52, мөсний шагай 81, хурдан морь унаач 45, ширээний шагай 10, бугуйлдагч 6 нийт 1048 тамирчид үндэсний спортоор хичээллэж байна.
Хэрэгжилтийн дундаж-80%												

АЙМГИЙН ХӨГЖЛИЙН 2025 ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮЗҮҮЛЭЛТ:
/БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗАР /

д/д	Зорилтот үр дүн	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь он	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Биелэлтийн хувь
ТЕЗ-н үр дүн:								
1	Идэвхтэй хөдөлгөөн хийдэг иргэдийг нэмэгдүүлнэ.	Фитнесс клубт хичээллэгчдийн тоо	тоо	2024	2000	2200	Тайлант онд аймгийн хэмжээнд 15 фитнесс тогтмол үйл ажиллагаа явуулж байна. Фитнесс клубт хичээллэгчдийн тоог 210-аар нэмэгдүүлж, 2210 иргэн тогтмол хичээллэж байна.	100%
Хөтөлбөрийн үр дүн:								
2	Нийтийн биеийн тамирын ач холбогдлын талаар зөв мэдлэгтэй иргэдийг нэмэгдүүлж, орчин нөхцлийг сайжруулна.	Секц дугуйланд хичээллэгчдийн тоо	мянган. хүн	2023	22.9	24.0	Тайлант онд биеийн тамир, спортын 52 төрлийн секц дугуйланд хичээллэгчдийн тоог 1120-аар нэмэгдүүлж, 24020 иргэн тогтмол хичээллэж байна.	100%
3	Үндэсний спортоор хичээллэгчдийн тоог нэмэгдүүлнэ.	Хүртсэн медаль	тоо	2023	987	Амжилтаа бататгана.	Тайлант онд Орхон аймгийн тамирчид дэлхий, тив, олон улс, улс, бүсийн аварга шалгаруулах тэмцээн уралдаанд спортын 35 төрлөөр оролцож 995 медаль авсан амжилтыг үзүүлсэн. Үүнд: алтан медаль 263, мөнгөн медаль 215, хүрэл медаль 517. Үндэсний спортын 3 төрөлд хичээллэгчдийн тоог 58-аар нэмэгдүүлж, үндэсний спортын 8 төрөлд хичээллэгчдийн тоог 1048-д хүргэсэн. Үүнд: үндэсний бөх 458, үндэсний сур 220, шагай 176, мөсний сур харваа 52, мөсний шагай 81, хурдан морь унаач 45, ширээний шагай 10, бугуйлдагч 6 нийт 1048 тамирчид үндэсний спортоор хичээллэж байна.	100%
Хэрэгжилтийн дундаж-100%								